



ӨВҮРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Өмчийн хэлтсээс 2013-2016 онуудад зохион байгуулсан
дуудлагын худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалтын
үр дүн**



**Дуудлагын худалдааг журмын дагуу зохион байгуулж байгаа ч
бэлтгэл ажил хангалтгүй, худалдсан хөрөнгийн орлогыг
хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг
үрэлгэн зарцуулсан байна.**

2017 он

ААГ-14/2017/02-ГА

2017 оны 06 дугаар сар

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ӨВӨРХАНГАЙ ДАХЬ ТӨРИЙН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор (Л.Ламаачин)</p> <p>Аудитын менежер (Ц.Отгонням)</p> <p>Ахлах аудитор (Б.Чимэдцэрэн)</p> <p>Аудитор (С.Шийлэгмаа)</p> <p>Шинжээч (Ч.Гантулга)</p> <p>2017 оны 6 дугаар сар</p> <p>Уг тайланг АГ-ын https://www.facebook.com/uuvurkhangai.audit facebook хаягаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас, 70323253</p>	<p>Товчилсон үгийн тайлбар4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5</p> <p>Бүлэг 1</p> <p>Дуудлагын худалдаа явуулах бэлтгэл ажил хангалтгүй байна.</p> <ul style="list-style-type: none">✚ Ул хөдлөх хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн, хөдлөх хөрөнгийг Аймгийн Засаг даргын шийдвэрээр дуудлагын худалдаагаар худалдаж байна.✚ Дуудлагын худалдааг хууль, журамд заасан хоногоос цөөн хоногийн өмнө зарлан мэдээлж байна.✚ Дуудлагын худалдаагаар худалдах зарим хөрөнгийн доод үнийг үндэслэлтэй тогтоогоогүй байна.✚ Зохион байгуулах комиссыг журмын дагуу тухай бүрд томилоогүй, дуудлагын худалдаа явуулахаад томилогдсон гишүүдийн зарим нь оролцоогүй байна. <p>Бүлэг 2</p> <p>Худалсан хөрөнгийн орлогыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг үрэлгэн зарцуулсан байна.</p> <ul style="list-style-type: none">✚ Дуудлагын худалдаанд оролцогчдыг журмын дагуу бүртгэж, тэдний эрх, үүрэг хангагдаж байна.✚ Дуудлагын худалдааны дэнчинг журамд заасны дагуу тогтоосон байна.✚ Дуудлагын худалдаанд оролцогчид үнэ хаялцахгүйгээр үгсэн хуйвалдаж хөрөнгийг худалдан авч байна.✚ Дуудлагын худалдааг зохион байгуулж буй комисс журмын дагуу ажиллаж байна.✚ Дотоодын болон хөндлөнгийн хяналт сулаас журамд заасан хугацаанд хөрөнгө худалдсаны орлогыг орон нутгийн өмчийн санд төвлөрүүлээгүй, оролцогчийн төлсөн хураамжийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
--	--

дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:
(Өвөрхангай аймаг
Арвайхээр сум 5-р баг
Нутгийн удирдлагын
ордон 405 тоот)

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал:

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Хавсралтууд

ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХЗХ	Хууль зүйн хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
М.КВ	мөтр квадрат

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторт Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгын дагуу, Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан ҮАГ-14/2017/ГА-02 төлөвлөгөөг үндэслэн Өмчийн хэлтсээс 2013-2016 оны хооронд зохион байгуулсан дуудлагын худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалтын үр дүнд аудитыг гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Өмчийн хэлтсээс 2013-2016 оны хооронд зохион байгуулсан дуудлагын худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалт үр дүнтэй эсэхийг шалгаж, дүгнэлт гарган ҮАГ болон аймгийн ИТХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах үндсэн асуудлаар аудитыг гүйцэтгэсэн болно.
Үүнд:

- Дуудлагын худалдаа явуулах бэлтгэл ажил үр дүнтэй хангагдаж байгаа эсэх
- Дуудлагын худалдааны зохион байгуулалт, оролцогчдын хураамжийн зарцуулалт хууль, журмын дагуу үр нөлөөтэй байгаа эсэх

Хамрах хүрээ:

Өмчийн хэлтсээс 2013-2016 оны хооронд зохион байгуулсан дуудлагын худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалтын үр дүнг ирүүлсэн ажлын тайлан, холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан, холбогдох албан тушаалтуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, өгөгдөл дүн шинжилгээ хийх, түүвэрчлэх, ажиглалт, ажил гүйлгээний сорил гэх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Иргэний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчтэй хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам"
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчтэй хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх актлах журам"
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан УАГ-14/2017/ГА-02 аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг ахлах аудитор Б.Чимэдцэрэн, аудитор С.Шийлэгмаа, шинжээч Ч.Гантулга нар 2017 оны 5 дугаар сарын 15-аас 6 дугаар сарын 14-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Дуудлагын худалдааг журмын дагуу зохион байгуулж байгаа ч бэлтгэл ажил хангалтгүй, худалдсан хөрөнгийн орлогыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг үрэлгэн зарцуулсан байна.

БҮЛЭГ-1

Дуудлагын худалдаа явуулах бэлтгэл ажил хангалтгүй байна.

1.1 Үл хөдлөх хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн, хөдлөх хөрөнгийг Аймгийн Засаг даргын шийдвэрээр дуудлагын худалдаагаар худалдаж байна.

Орон нутгийн өмчтэй байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үл хөдлөх хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдахаар аймгийн ИТХ-ын тогтоол 2013 онд 2, 2014 онд 1, 2015 онд 4, 2016 онд 4 нийт 11 удаагийн тогтоол гарчээ.

Үнэ тогтоох комиссын шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоосон захирамж 2013-2014 онд тус бүр 3, 2015-2016 онд тус бүр 4 удаа гаргасны дагуу дуудлага худалдааг зохион байгуулсан байна.

1.2 Дуудлагын худалдааг хууль, журамд заасан хоногоос цөөн хоногийн өмнө зарлан мэдээлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1. “Дуудлагын худалдаа явуулах зар, мэдээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү ажиллагааг явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ” гэснийг үндэслэх талаар аймгийн ИТХ-ын баталсан журамд заажээ. Аудитад хамрагдсан хугацааны дуудлагын худалдааны зар мэдээг орон нутгийн Таны элч сонин болон Соёмбо, GM төлөвизүүдтэй гэрээ байгуулан байршуулсан байгаа боловч журам зөрчсөн байна. Үүнд:

- 2013 онд зохион байгуулсан дуудлагын худалдаануудын зарыг орон нутгийн төлөвizzээр явуулаагүй, харин Таны элч сонинд хэд хоногийн өмнө мэдээллийг байршуулсан нь тодорхой бус байна.
- 2014 онд зохион байгуулсан дуудлагын худалдааг орон нутгийн төлөвizzээр зар явуулаагүй, Таны элч сонинд 6-26 хоногийн өмнө мэдээллийг байршуулжээ.
- 2015 онд зохион байгуулсан 3 дуудлагын худалдааны зарыг Таны элч сонинд 6, 15, 32 хоногийн өмнө мэдээлж, 1 дуудлагын худалдааны зарыг мэдээлсэн эсэх нь тодорхойгүй байна.
- 2016 онд зохион байгуулсан 3 дуудлагын худалдааны зарыг Таны элч сонинд 10, 10, 35 хоногийн өмнө, 1 дуудлага худалдааны орон нутгийн төлөvizzээр 14 хоногийн өмнө мэдээлжээ.

1.3 Дуудлагын худалдаагаар худалдах зарим хөрөнгийн доод үнийг үндэслэлтэй тогтоогоогүй байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны а/182, 2015 оны а/262 дугаар захирамжуудаар үнэ тогтоох комиссын бүрэлдэхүүнийг томилжээ. Дээрх комиссын шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын Захирамжаар дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоодог байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам болон 2015 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх актлах журамд үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг заажээ. Үүнд:

Үл хөдлөх хөрөнгийн хувьд: Балансын үнэ (анхны, үлдэгдэл үнэ, ашиглалтын үеийн элэгдэл); Сүүлчийн их засвар, хөрөнгө оруулалтын зардал; Үл хөдлөх хөрөнгө байршин байгаа нутаг дэвсгэрийн газрын сангийн зэрэглэлийн нэгж талбайн суурь үнэлгээ; Үл хөдлөх хөрөнгийн гадна инжөнөрийн байгууламж, шугам сүлжээ болон

нийтийн тохижилтүн хөрөнгийн үнэ; Үл хөдлөх хөрөнгийн бизнэсийн үнэлгээ; Мэргэжлийн байгууллагын дүгнэлт; Зах зээлийн судалгаа эрэлт, хэрэгцээ биет байдал;

Хөдлөх хөрөнгийн хувьд: Гарал, үүсэл; Ашигласан хугацаа; Ерөнхий болон төхникийн төлөв байдал; Балансын үнэ (анхны, үлдэгдэл үнэ, ашиглалтын үеийн элэгдэл); Ашиглагдах үеийн сүүлийн 3-н жилийн сэргээн босголтын зардал; Зориулалт, төрөл; Зах зээлийн эрэлт, хэрэгцээ зэргийг үндэслэн дуудлагын худалдааны доод үнийг тогтооно гэжээ.

Мэргэжлийн байгууллагын дүгнэлт, их засвар, хөрөнгө оруулалтын зардал, зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан үзэлгүйгээр Хангамжийн 24 айлын орон сууцны 3 өрөө, Хуримын ордны урд байрлах 12 айлын орон сууцны 3 өрөө байруудын доод үнийг тогтоохдоо гал тогоо, ариун цэврийн өрөө, коридорын хэмжээг оруулахгүйгээр 3 өрөө байрны талбайн хэмжээг 48 м.кв-аар тооцон тухайн үеийн байрны зах зээлийн ханш 1 м.кв нь 1.2 сая төгрөг /2013 оны 6 дугаар сар/ байхад 0.8-0.9 сая төгрөгөөр үнэлсэн байна.

Авто тээврийн хэрэгслийн хувьд ашигласан хугацаа, эдэлгээ болон засвар үйлчилгээ хийгдсэнээс хамааран доод үнийг комиссын гишүүдийн саналаар тогтоосон байна.

Үл хөдлөх хөрөнгийн доод үнийг тогтоохдоо 2015 оноос эхлэн хөрөнгийн үнэлгээний газраар үнэлгээ хийлгэдэг болсноор Лэндс ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан дуудлагын худалдаагаар худалдахаар оруулсан хөрөнгийн үнэлгээг хийлгэж байна.

1.4 Зохион байгуулах комиссыг журмын дагуу тухай бүрд томилоогүй, дуудлагын худалдаа явуулахад томилогдсон гишүүдийн зарим нь оролцоогүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам болон 2015 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх актлах журмын 3.13.1-т “Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах комиссыг (цаашид “Зохион байгуулах комисс” гэх) Аймгийн Засаг даргын захирамжаар тухай бүрд томилно” гэж заасан байна.

Гэтэл аймгийн Засаг даргын 2013 оны 4 дүгээр сарын 15-ны а/122 дугаар захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан дуудлага худалдааг зохион байгуулах комисс огт солигдолгүйгээр 2013-2015 оны дуудлага худалдааг зохион байгуулжээ.

Аймгийн засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн а/34 тоот захирамжаар дуудлагын худалдааг зохион байгуулах комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Дээрх комисст орсон гишүүдээс дуудлагын худалдаа зохион байгуулахад аймгийн ЗДТГ-ын ХЗХ-ийн ахлах мэргэжилтэн Т.Үржинпүрэв, А.Отгонцэцэг нар огт оролцоогүй, СТСХ-ийн ахлах мэргэжилтэн Р.Цэрэндэжид заримд нь оролцоогүй байна.

БҮЛЭГ-2

Худалдсан хөрөнгийн орлогыг хугацаанд нь төсөөт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг үрэлгэн зарцуулсан байна.

2.1 Дуудлагын худалдаанд оролцогчдыг журмын дагуу бүртгэж, тэдний эрх, үүрэг хангагдаж байна.

Дуудлагын худалдаанд оролцогчдыг журмын дагуу бүртгэж, “Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт”-ийг бөглүүлэн дэнчин, хураамжийг авсан байна. Дуудлагын худалдаанд оролцож ялагч болоогүй иргэдэд дэнчинг буцаан олгожээ.

2.2 Дуудлагын худалдааны дэнчинг журамд заасны дагуу тогтоосон байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам болон Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх актлах журмын 3.11.1-т “Дуудлагын худалдаагаар худалдаах эд хөрөнгийн худалдаах доод үнэ 10.000.000 (Арван сая) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдаах доод үнийн 30 хүртэл гэхдээ 10-аас багагүй хувиар, 10.000.001 (Арван сая нэг) төгрөгөөс дээш бол дэнчингийн хэмжээг худалдаах доод үнийн 10 хувиар тогтооно” гэж заасны дагуу дуудлагын худалдаанд орж буй хөрөнгийн дэнчингийн хэмжээг тогтоож ирсэн байна.

2.3 Дуудлагын худалдаанд оролцогчид үнэ хаялцахгүйгээр үgsэн хуйвалдаж хөрөнгийг худалдан авч байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан 2011 оны болон 2015 оны журамд дуудлагын худалдааны үнэ хаялцах хязгаарыг дараах байдлаар тогтоосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Дуудлагын худалдааны доод үнэ	Үнэ хаялцах доод хязгаар /мянган төгрөг/		Үнэ хаялцах дээд хязгаар /мянган төгрөг/	
	2011 оны журмаар	2015 оны журмаар	2011 оны журмаар	2015 оны журмаар

100.0 мянган төгрөг хүртэл	-	50.0	-	150.0
100.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	50.0	100.0	100.0	150.0
10,000.0 мянган төгрөгөөс дээш	100.0	200.0	дэнчингийн хэмжээтэй тэнцүү	дэнчингийн хэмжээтэй тэнцүү

Дуудлагын худалдаанд оролцогчид үнэ хаялцах доод хязгаарыг баримтлан оролцогчдын зөвхөн нэг нь ганцхан удаа үнэ дуудаж ялагч болж байгаа нь хоорондоо үгсэн хуйвалдсан болохыг харуулж байна. Тухайлбал:

- 2013 онд 4 удаагийн дуудлагын худалдаагаар давхардсан тоогоор 21 хөрөнгийг дуудахад 2 автомашин оролцогчгүй, 1 нь 5 оролцогчтой /Аймгийн Цагдаагийн газрын Уа3-31512 маркийн суудлын авто машины худалдах доод үнэ 1.0 сая төгрөг байсан бөгөөд дуудлага худалдаанд 5 оролцогч оролцож, үнэ хаялцаар иргэн С.Мөнхбаяр 4.8 сая төгрөгөөр авахаар ялагч болсон боловч үнийг төлөөгүйн улмаас хүчингүй болж, 3 сарын дараа дахин дуудлага худалдаанд орсон/, бусад нь бүгд 2 оролцогчтой бөгөөд нэг нь огт үнэ дуудахгүй, нөгөө нь үнэ хаялцах доод хязгаараар нэг удаа үнэ хэлж ялагч болсон.
- 2014 оноос эхлэн дуудлагын худалдаанд оролцогч тус бүрээр үнэ дуудуулдаг болсноор худалдагдаж буй хөрөнгө үнэ хаялцах доод хязгаараар оролцогчдын тоогоор нэмэгдэж худалдаалагдаж байна.

2.4 Дуудлагын худалдааг зохион байгуулж буй комисс журмын дагуу ажиллаж байна.

Хууль, журмын дагуу дуудлагын худалдаанд нэг ч этгээд ирээгүй, хоёроос доош этгээд ирсэн, худалдах доод үнээс дээш үнийн санал гараагүй бол дуудлагын худалдааг явагдаагүйд тооцон, энэ тухай тэмдэглэл үйлдэн, гарын үсэг зурсан байна.

Дуудлагын худалдааны хөтлөгч нь үнэ хаялцах хамгийн доод болон дээд хязгаарыг зарлаж, дуудлагын худалдаанд оролцогчдод пайз олгон үнийн саналыг пайз өргөсөн дарааллаар дуудсан талаар дуудлагын худалдааны тэмдэглэлд тусгажээ.

2.5 Дотоодын болон хөндлөнгийн хяналт сулаас журамд заасан хугацаанд хөрөнгө худалсаны орлогыг орон нутгийн өмчийн санд төвлөрүүлээгүй, оролцогчийн төлсөн хураамжийг зориуулалтын дагуу зарцуулаагүй байна.

Журмын 3.14.3-т “Дуудлагын худалдаанд ялагч худалдан авсан эд хөрөнгийн үнийг “Худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулснаас хойш 14 хоногийн дотор Өв.хөрөнгө худалсаны орлого дансанд тушаах бөгөөд энэ хугацаанд төлөөгүй бол дэнчинг орон нутгийн төсвийн орлого болгож, худалдан авах эрх дараагийн үнийн

санал гаргасан оролцогчид шилжинэ. Уг оролцогч төлбөрийг 14 хоногийн хугацаанд төлнө”, 3.14.4-т “Дуудлагын худалдаагаар худалдан авсан хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх нь Худалдах, худалдан авах гэрээний дагуу үнийг хугацаанд нь бүрэн төлсний дараа, үл хөдлөх хөрөнгийн хувьд үнийг бүрэн төлж, үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлсний дараа үүснэ”, 3.15.1-т “Энэ журмын 3.12.4-д заасны дагуу дуудлагын худалдаа явагдаагүй буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үндэслэлээр хууль зөрчин явуулсанд тооцсон, түүнчлэн энэ журмын 3.13.3-д зааснаар дараагийн оролцогч тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол уг дуудлагын худалдааг дахин явуулна”, 3.15.2-т “Дуудлагын худалдааг дахин явуулах тухай шийдвэрийг аймгийн Засаг даргын захирамжаар гаргах бөгөөд дахин дуудлагын худалдаа явуулах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө энэ тухай мэдээлнэ”, 3.15.3-т “Дуудлагын худалдаа дахин явуулахдаа энэ журмыг баримтална” гэж заасан байхад дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

2013 онд:

- 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдөр явуулсан дуудлагын худалдаагаар худалсан Хархорин сумын Энэрэл Хархорин өрхийн эмнэлгийн Hyundai accent, Арвайхээр сумын ИТХ-ын Mitsubishi Pajero, Гучин-Ус сумын ЗДТГ-ын Land Cruiser маркийн авто машинуудын үнэ нийт 4.8 сая төгрөгийг тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр ялагч болсон иргэдээс бэлнээр авсныг орон нутгийн өмчийн санд төвлөрүүлэхгүйгээр Өмчийн хэлтсийн дарга Н.Ганболд өөрөө жил гаруйн хугацаанд ашиглаж байгаад 2015 оны 1 дүгээр сарын 16-нд төсөвт оруулсан.
- Хангамжийн 24 айлын орон сууцны 2-14 тоотын 3 өрөө байрыг 38.1 сая төгрөгөөр худалдан авсан Н.Энхцэцэг 34.3 сая төгрөгийг 18 хоногийн дараа, 12 айлын орон сууцны 1-6 тоотын 3 өрөө байрыг 43.1 сая төгрөгөөр худалдан авсан Т.Төмөрчөдөр 0.8 сая төгрөгийг 4 сарын дараа тус, тус төлсөн байна.

2014 онд:

- 2014 оны 12 дугаар сарын 29-ний өдөр явуулсан дуудлагын худалдаагаар худалсан Таратт сумын ЭМТ-ийн УАЗ-31512, Богд сумын ЗДТГ-ын land cruiser-105, . Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Toyota hilux маркийн автомашинуудын үнийг иргэн Д.Сүрэнхорол, Ч.Адъяа, Д.Батбаяр нар 22-78 хоногийн дараа, Бат-Өлзий сумын ЭМТ-ийн УАЗ-31512 маркийн автомашины үнэ 1 жилийн дараа төлөгдсөн байна. Бат-Өлзий сумын ЭМТ-ийн УАЗ-31512 маркийн автомашины дуудлага худалдаанд Д.Сүрэнхорлоо, н.Хишигмаа нар оролцон н.Хишигмаа нь ялж хөрөнгийг худалдан авах гэрээ хийгдсэн боловч төлбөрийг оролцогч Сүрэнхорлоо төлжээ.

2015 онд:

- Хархорин ИТХ-ын Challenger, Сант ЗДТГ-ын Bongo Frontier маркийн автомашинууд, Богд ЗДТГ-ын Наадмын талбай, Дизелийн барилгын үнийг иргэн

Б.Чинбат, Э.Мөнхбат, Г.Оюунгэрэл, Р.Адъяасүрэн нар 15-16 хоногийн дараа төлсөн байна.

2016 онд:

- 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн дуудлагын худалдаагаар Сант сумын ЭМТ-ийн УАЗ-31512 маркийн авто машиныг 5.3 сая төгрөгөөр авсан Д. Сүрэнхорлоо нь худалдах худалдан авах гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө худалдсаны орлогын дансанд үнийг төлөөгүй байна. Гэтэл дуудлага худалдааг дахин явуулаагүй бөгөөд 1 сарын дараа буюу 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдөр тус авто машиныг 1.5 сая төгрөгөөр үнэ тогтоож худалдахаар аймгийн засаг даргын а/570 тоот захирамж гарч иргэн Д. Сүрэнхорлоо худалдан авсан байна.

Журамд оролцогчийн хураамж нь эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр худалдах доод үнийн 5 хувь байх, хураамжийг дуудлага худалдааг зарлан мэдээлэх, зохион байгуулах болон үйл ажиллагааны зардалд зарцуулна гэж заажээ.


2013 онд зохион байгуулсан зарим дуудлагын худалдааны оролцогчийн хураамжийг авахдаа журамд заасан хувийг баримтлаагүй байна. Үүнд:

- 4 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан дуудлагын худалдаанд 6 авто машиныг худалдан авахаар 16 хүн бүртгүүлэхэд оролцогч тус бүрээс 30.0 мянган төгрөг, нийт 0.5 сая төгрөг авчээ. Журмын дагуу худалдах доод үнийг харгалзан 5 хувиар тооцон авсан бол 1.2 сая төгрөгийн хураамж авах байсан байна.
- 8 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй Хангамжийн 24 айлын орон сууцны 2-14 тоотын 3 өрөө, 12 айлын орон сууцны 1-6 тоотын 3 өрөө байрны худалдах доод үнийг 38.0 сая төгрөг болон 43.0 сая төгрөгөөр тогтоосон дуудлагын худалдааны байхад оролцогчийн хураамжийг тус бүр 0.5 сая төгрөгөөр тооцож, нийт 2.0 сая төгрөгийн хураамж авсан. Үүнийг журмын дагуу авсан бол 8.1 сая төгрөгийн хураамж авах байжээ. Журам зөрчсөний улмаас дээрх 2 дуудлагын худалдааны оролцогчийн хураамжийг 6.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ.

Аудитад хамрагдсан тайлант онуудад дуудлагын худалдаанд оролцогчдын хураамжаас нийт 20.9 сая төгрөг төвлөрсний 6.5 хувийг зар сурталчилгааны төлбөрт, 6.6 хувийг үнэлгээ хийлгэсний хөлсөнд, 4.7 хувийг бичиг хэрэг, шуудан холбооны зардалд, 46.8 хувийг шатахуун, сэлбэг хэрэгслийн зардалд, 26.6 хувийг хоол хүнс, архи

дарс, чихэр жимс худалдан авахад, 8.8 хувийг бусад зардалд зарцуулжээ.

Оролцогчийн хураамжийн 2013-2016 оны орлогын зарцуулалт



- Зар сурталчилгааны төлбөр
- Уйлчилгээний зардал
- Бичиг хэрэг, шуудан холбооны зардал
- Шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал
- Хоол хүнс, архи, ундаа, ус, чихэр худалдан авсан зардал
- Бусад зардал

Эдгээр зардлыг хүснэгтээр харуулбал:

Д/д	Зардлын нэр төрөл	Зардлын дүн /мянган төгрөгөөр/				
		2013 он	2014 он	2015 он	2016 он	Бүгд
1	Зар сурталчилгааны төлбөр	-	333.7	531.1	504.0	1,368.8
2	Үнэлгээний зардал	-	320.0	150.0	920.0	1,390.0
3	Бичиг хэрэг, шуудан холбооны зардал	-	99.8	876.9		976.7
4	Шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал	2,101.5	6,258.8	1,218.0	225.0	9,803.3
5	Хоол хүнс, архи, ундаа, чихэр худалдан авахад	1,338.5	2,889.7	714.0	622.9	5,565.1
6	Бусад зардал	580.0	662.0	287.8	312.5	1,842.3
Нийт зардал		4,020.0	10,564.0	3,777.8	2,584.4	20,946.2

Дуудлагын худалдааны хураамжийн орлого, зарлагад бэлэн мөнгөний гүйлгээний тайлангаас өөр бүртгэл хөтлөгдөхгүй, гүйлгээг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгахгүй, зөвхөн хэлтсийн даргын мэдлийн хүрээнд зарцуулагдаж ирсэн байгаа нь Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчсөн байна.

Аудитаар 25.0 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 12.6 сая төгрөгийн албан шаардлага өгч, 5.6 сая төгрөгийн акт тогтоов.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглувулсан нотлох зүйлс, аудитын дунд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Дуудлагын худалдааг журмын дагуу зохион байгуулж байгаа ч бэлтгэл ажил хангалтгүй, худалдсан хөрөнгийн орлогыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг үрэлгэн зарцуулсан байна.

- + Ул хөдлөх хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн, хөдлөх хөрөнгийг Аймгийн Засаг даргын шийдвэрээр дуудлагын худалдаагаар худалдаж байна.
- + Дуудлагын худалдааг хууль, журамд заасан хоногоос цөөн хоногийн өмнө зарлан мэдээлж байна.
- + Дуудлагын худалдаагаар худалдах зарим хөрөнгийн доод үнийг үндэслэлтэй тогтоогоогүй байна.
- + Зохион байгуулах комиссыг журмын дагуу тухай бурд томилоогүй, дуудлагын худалдаа явуулахад томилогдсон гишүүдийн зарим нь оролцоогүй байна.
- + Дуудлагын худалдаанд оролцогчыг журмын дагуу бүртгэж, тэдний эрх, үүрэг хангагдаж байна.
- + Дуудлагын худалдааны дэнчинг журамд заасны дагуу тогтоосон байна.
- + Дуудлагын худалдаанд оролцогчид үнэ хаялцахгүйгээр үгсэн хуйвалдаж хөрөнгийг худалдан авч байна.
- + Дуудлагын худалдааг зохион байгуулж буй комисс журмын дагуу ажиллаж байна.
- + Дотоодын болон хөндлөнгийн хяналт сулаас журамд заасан хугацаанд хөрөнгө худалдсаны орлогыг орон нутгийн өмчийн санд төвлөрүүлээгүй, оролцогчийн төлсөн хураамжийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Ганболд, Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн М.Нинжбадгар, Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн В.Дэлгэрмаа нарт:

1. Дуудлагын худалдааны зар мэдээллийг хууль, журамд заасны дагуу дуудлагын худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө зарлан мэдээлж байх
2. Орон нутгийн өмчйт хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх актлах журмын 3.13.1-т заасны дагуу дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах комиссыг тухай бүрд аймгийн Засаг даргын захирамжаар томилуулж, томилогдсон гишүүдийг дуудлагын худалдааны ажиллагаанд оролцуулж байх
3. Дуудлагын худалдаагаар худалдсан хөрөнгийн орлогыг тухай бүрд төсөвт төвлөрүүлж байх
4. Оролцогчийн хураамжийн орлого, зарлагын гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу бүртгэж, санхүүгийн тайланд тусгаж, зориулалтын бусаар зарцуулахгүй байх

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР